



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК -ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/036/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас:51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор: Г.Тэлмүүн Утас: 51-261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn Азуре хүлүг аудит ХХК-ийн захирал: Г.Мөнхбаяр Утас:70110090 Цахим хаяг:audit@azure.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1054  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ  
СҮЛЖЭЭ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Б.МӨНХБАТ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 622 дугаар тогтоолын дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төслийн хүрээнд бий болсон 17 нэрийн 1,213.3 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг бүртгэсэн байна. Мөн Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслийн хүрээнд бий гадна холбооны сувагчлалын 27 нэр төрлийн 1,372.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хүлээн авсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 700 дугаар тогтоолоор баталсан 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшиний төлөвлөгөөнд нийт орлогыг 65,725.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 63,923.1 сая төгрөгөөр, 1,321.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 67,539.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 65,630.5 сая төгрөгийн зардал гарган, 1,462.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,894,777,273.10	4,389,755,120.42
1.1.02	Дансны авлага	10,270,029,214.66	10,591,178,079.45
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	376,604,674.92	442,532,143.72
1.1.04	Бусад авлага	290,167,730.03	399,572,457.44
1.1.06	Бараа материал	3,533,169,040.43	4,102,073,386.41
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	872,506,424.53	1,466,689,926.03
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>18,237,254,357.67</b>	<b>21,391,801,113.47</b>
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.01	Үндсэн хөрөнгө	126,711,907,761.75	123,963,947,736.20
1.2.02	Биет бус хөрөнгө	50,577,627,584.96	55,344,266,582.74
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	2,094,943,742.63	2,795,301,609.00
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	4,485,842,480.47	114,992,727.27
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>183,870,321,569.81</b>	<b>182,218,508,655.21</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>202,107,575,927.48</b>	<b>203,610,309,768.68</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.01	Дансны өглөг	1,497,140,543.42	2,810,459,031.91
2.1.1.03	Татварын өр	115,760,830.96	917,681,094.21
2.1.1.04	НДШ - ийн өглөг	-	173,761,473.80
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	6,237,684.92	9,197,483.79
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,045,371,140.93	899,349,395.57
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,664,510,200.23</b>	<b>4,810,448,479.28</b>
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.01	Урт хугацаат зээл	33,985,228,886.65	31,861,150,956.27
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	3,875,172,492.66	4,039,965,877.94
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	35,181,688,628.89	32,962,857,952.21
<b>2.1.2.06</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>73,042,090,008.20</b>	<b>68,863,974,786.42</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>75,706,600,208.43</b>	<b>73,674,423,265.70</b>
2.3	Эздийн өмч		
2.3.01	Өмч: - төрийн	137,551,494,711.54	137,551,494,711.54
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16,115,545,818.58	16,087,046,321.35
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	63,732,485,940.51	66,175,258,324.60
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(90,998,550,751.58)	(89,877,912,854.51)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>126,400,975,719.05</b>	<b>129,935,886,502.98</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>202,107,575,927.48</b>	<b>203,610,309,768.68</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	57,826,314,900.67	64,871,865,398.18
2	Борлуулалтын өртөг	50,980,915,466.50	55,473,049,706.06
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>6,845,399,434.17</b>	<b>9,398,815,692.12</b>
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	81,431,124.99	13,526,825.43
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	2,243,466,716.54	2,228,641,597.02
9	Борлуулалт, маркетингийн зардал	481,103,269.85	557,542,884.47
10	Ерөнхий ба удирдлагын зардал	5,245,792,872.64	6,146,652,412.88
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	1,885,325,830.31	3,233,652,580.70
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	1,119,761.25	(54,728,980.96)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	16,175,454.53	260,530,357.95
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг ( алдагдал)	-	-
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>1,575,370,518.68</b>	<b>1,908,937,613.51</b>
19	Орлогын татварын зардал	197,065,772.82	330,536,170.91
19.1	Хойшлогдсон татварын зардал	145,044,547.52	116,284,982.76
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>1,233,260,198.34</b>	<b>1,462,116,459.84</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>1,233,260,198.34</b>	<b>1,462,116,459.84</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
<b>24</b>	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү</b>	-	-
<b>25</b>	<b>Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү</b>	-	-
<b>26</b>	<b>Бусад олз (гарз)</b>	-	-
<b>27</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>1,233,260,198.34</b>	<b>1,462,116,459.84</b>
<b>28</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>137,551,494,711.54</b>	<b>16,116,558,631.08</b>	<b>42,054,545,025.75</b>	<b>(91,054,776,542.42)</b>	<b>104,667,821,825.95</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	1,012,812.50	1,012,812.50
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>137,551,494,711.54</b>	<b>16,116,558,631.08</b>	<b>42,054,545,025.75</b>	<b>(91,053,763,729.92)</b>	<b>104,668,834,638.45</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,233,260,198.34	1,233,260,198.34
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	21,677,940,914.76	-	21,677,940,914.76
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	(1,178,047,220.00)	(1,178,047,220.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(1,012,812.50)	-	-	(1,012,812.50)
9	<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>137,551,494,711.54</b>	<b>16,115,545,818.58</b>	<b>63,732,485,940.51</b>	<b>(90,998,550,751.58)</b>	<b>126,400,975,719.05</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	28,499,497.23	28,499,497.23
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>137,551,494,711.54</b>	<b>16,115,545,818.58</b>	<b>63,732,485,940.51</b>	<b>(90,970,051,254.35)</b>	<b>126,429,475,216.28</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,462,116,459.84	1,462,116,459.84
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	2,442,772,384.09	-	2,442,772,384.09
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	(369,978,060.00)	(369,978,060.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(28,499,497.23)	-	-	(28,499,497.23)
17	<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>137,551,494,711.54</b>	<b>16,087,046,321.35</b>	<b>66,175,258,324.60</b>	<b>(89,877,912,854.51)</b>	<b>129,935,886,502.98</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>60,546,562,934.54</b>	<b>68,322,926,966.14</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	60,152,553,560.47	68,013,178,584.62
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	18,790,520.60	6,708,262.40
	Бусад мөнгөн орлого	375,218,853.47	303,040,119.12
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>51,714,068,683.49</b>	<b>57,029,471,869.43</b>
	Ажиллагчдад төлсөн	18,699,502,740.21	21,811,513,953.12
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,524,578,076.42	6,038,117,741.90
	Бараа материал худалдан авахад төлсөн	2,131,982,746.55	2,299,792,118.40
	Ашиглалтын зардалд төлсөн	12,072,646,401.84	13,055,071,738.57
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,312,576,327.49	3,264,731,540.02
	Хүүгийн төлбөрт төлсөн	809,864,534.08	761,514,412.63
	Татварын байгууллагад төлсөн	6,909,039,770.61	6,368,447,369.09
	Даатгалын төлбөрт төлсөн	62,535,266.56	64,005,562.85
	Бусад мөнгөн зарлага	2,191,342,819.73	3,366,277,432.85
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>8,832,494,251.05</b>	<b>11,293,455,096.71</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>99,224,124.99</b>	<b>440,448,402.74</b>
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	17,793,000.00	427,045,000.00
	Хүлээн авсан хүүгийн орлого	81,431,124.99	13,403,402.74
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>10,063,432,280.37</b>	<b>7,691,629,331.59</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,511,742,185.37	7,329,003,977.84
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	551,690,095.00	362,625,353.75
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(9,964,208,155.38)</b>	<b>(7,251,180,928.85)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>43,569,083.50</b>	<b>11,402,416.51</b>
	Төрөл бүрийн хандив	-	-
	Бусад	43,569,083.50	11,402,416.51
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>3,340,377,927.05</b>	<b>2,558,698,737.05</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,124,095,930.38	2,124,077,930.38
	Төлсөн ногдол ашиг	1,178,047,220.00	369,978,060.00
	Бусад	38,234,776.67	64,642,746.67
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(3,296,808,843.55)</b>	<b>(2,547,296,320.54)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(4,428,522,747.88)</b>	<b>1,494,977,847.32</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>7,323,300,020.98</b>	<b>2,894,777,273.10</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,894,777,273.10</b>	<b>4,389,755,120.42</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 оны Гүйцэтгэл	2024 он		Харьцуулалт	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</b>						
1	Сувгийн үйлчилгээ	мян.төг	29,536,625.9	30,750,525.6	31,756,732.5	103.3	1,006,206.9
	Улс хоорондын сүлжээний үйлчилгээ	мян.төг	4,415,959.9	6,490,360.0	5,514,552.0	85.0	(975,808.1)
	Худаг сувагчлал	мян.төг	5,349,300.3	5,370,546.8	5,521,787.0	102.8	151,240.2
	Байр талбай, антенн түрээс	мян.төг	11,939,866.6	12,351,150.4	13,272,599.6	107.5	921,449.2
	Хэрэглэгчийн шугам	мян.төг	239,821.1	240,240.0	240,000.0	99.9	(240.0)
	Техник менежмент	мян.төг	6,344,741.1	8,127,929.5	8,566,194.3	105.4	438,264.8
	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	2,402,139.8	2,394,707.0	2,667,566.7	111.4	272,859.6
<b>2</b>	<b>Нийт орлого</b>	<b>мян.төг</b>	<b>60,228,454.7</b>	<b>65,725,459.4</b>	<b>67,539,432.0</b>	<b>102.8</b>	<b>1,813,972.6</b>
<b>3</b>	<b>Нийт зардал</b>	<b>мян.төг</b>	<b>58,653,084.1</b>	<b>63,923,147.0</b>	<b>65,630,494.4</b>	<b>102.7</b>	<b>1,707,347.4</b>
3.1	Үүнээс: Удирдлагын зардалд	мян.төг	771,781.4	799,733.4	796,882.4	99.6	(2,851.0)
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	1,575,370.5	1,802,312.4	1,908,937.6	105.9	106,625.2
<b>5</b>	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>мян.төг</b>	<b>1,233,260.2</b>	<b>1,321,150.4</b>	<b>1,462,116.5</b>	<b>110.7</b>	<b>140,966.1</b>
<b>6</b>	<b>Төсвийн төлбөр</b>	<b>мян.төг</b>	<b>12,433,486.4</b>	<b>11,390,804.5</b>	<b>12,406,564.9</b>	<b>108.9</b>	<b>1,015,760.4</b>
6.1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	мян.төг	419,498.8	209,157.0	361,229.3	172.7	152,072.3
6.2	Нэмэгдсэн өртгийн албан татвар	мян.төг	3,415,013.9	3,600,000.0	3,139,617.1	87.2	(460,382.9)
6.3	Газрын төлбөр	мян.төг	48,350.0	57,363.4	30,999.2	54.0	(26,364.2)
6.4	Агаарын бохирдлын төлбөр	мян.төг	611.5	746.8	366.9	49.1	(379.9)
6.5	Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	5,401.7	9,258.5	4,964.4	53.6	(4,294.1)
6.6	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	мян.төг	5,524,578.1	5,477,291.8	6,038,117.7	110.2	560,825.9
6.7	Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	229,159.1	211,304.8	235,289.5	111.4	23,984.7
6.8	ХХОАТ	мян.төг	1,722,266.9	1,570,384.6	2,250,433.1	143.3	680,048.5
6.9	Бусад	мян.төг	1,068,606.3	255,297.5	345,547.7	135.4	90,250.2
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	1,178,047.2	585,621.9	369,978.1	63.2	(215,643.9)
8	Ажиллагсдын тоо	хүн	1,318	1335	1314	98.4	(21.0)
9	Нийт цалингийн сан	мян.төг	18,667,934.6	21,618,540.0	22,123,448.0	102.3	504,908.0
10	Нэг ажилтны сарын дундаж цалин	мян.төг	1,180.3	1,349.5	1,403.1	104.0	53.6
11	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.97	0.97	0.97	99.9	(0.0)
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	12,841,980.8	12,440,541.4	6,826,235.2	54.9	(5,614,306.2)
13	Нийт авлага	мян.төг	10,270,029.2	6,099,498.4	10,591,178.1	173.6	4,491,679.7
14	Нийт өглөг	мян.төг	40,524,911.6	37,468,614.8	40,711,565.3	108.7	3,242,950.5
14.1	Үүнээс: богино хугацаат өр төлбөрт	мян.төг	2,664,510.2	1,652,968.0	4,810,448.5	291.0	3,157,480.5
14.2	Урт хугацаат өр төлбөрт	мян.төг	37,860,401.4	35,815,646.9	35,901,116.8	100.2	85,469.9

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 115.9 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 61.4 сая төгрөгийн алдааг залруулсан, 54.5 сая төгрөгийн залруулагдаагүй алдаанд 3 зөвлөмж өгсөн.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Гадаад 1 харилцагчийн 10 дугаар сарын транзит урсгалын төлбөрийн нэхэмжлэхийг ибаримтын системд 2.8 сая төгрөгөөр илүү дүнгээр үүсгэсэн байна.	1	2,858.4	-	-	1	2,858.4	-	-	1	2,858.4	1	2,858.4
2	Хэнтий, Дархан, Дорноговь, Ховд аймгуудад 661.2 сая төгрөгийн өртөгтэй 8 ширхэг үндсэн хөрөнгийн элэгдлийг 8.5 сая төгрөгөөр дутуу тооцоолж бүртгэсэн байна.	1	8,488.2	-	-	1	8,488.2	-	-	1	8,488.2	1	8,488.2
3	Бараа материалын үлдэгдлийг салбар тус бүрээр тулган шалгахад Багануур, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Төв, Дорноговь, Сүхбаатар, Увс, Өмнөговь аймгуудад 43.2 сая төгрөгийн өртөгтэй 18 ширхэг үндсэн хөрөнгийг дансны ангилал зөрүүтэй бүртгэсэн байна.	1	43,250.0	-	-	1	43,250.0	-	-	1	43,250.0	1	43,250.0

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

4	Нийгмийн даатгалын тайланг цалингийн тооцоололтой тулган шалгахад цалингийн тооцоололд байгаа 2 ажилтныг нийгмийн даатгалд тайлагнаагүй. Мөн 1 ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг зөрүүтэй тайлагнасан.	1	542.7	1	542.7	-	-	1	542.7	-	-	-	-
5	Салбар газруудын борлуулалтаар хүлээн зөвшөөрч авлага үүсгэсэн болон урьдчилан хүлээн авсан орлогын 60.8 сая төгрөгийг тайлант хугацааны эцсээр устгах тохиргоо бичилтийг хийгээгүй байна.	1	60,858.0	-	-	1	60,858.0	1	60,858.0	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>115,997.3</b>	<b>1</b>	<b>542.7</b>	<b>4</b>	<b>115,454.6</b>	<b>2</b>	<b>61,400.7</b>	<b>3</b>	<b>54,596.6</b>	<b>3</b>	<b>54,596.6</b>

3.2 Аудитаар нийт 24.5 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 24.5 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Бараа материалын дансны үлдэгдлийг тулган шалгахад орон нутгийн салбар газарт 7.9 сая төгрөгийн насжилт өндөртэй, ашиглах хугацаа дууссан түргэвчилсэн оношлуур, хангамжийн зүйлс бүртгэлтэй байна.	1	7,887.9	-	-	-	-	1	7,887.9	-	-	-	-	-	-
2	Мөнгөн урьдчилгааны тайлан, дараа тооцооны үлдэгдлийг шалгаж үзэхэд 16.6 сая төгрөгийн худалдан авалтын хугацаа, хавсралт баримтын мэдээлэл зөрүүтэй байна.	1	16,638.9	-	-	-	-	1	16,638.9	-	-	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>24,526.8</b>	-	-	-	-	<b>2</b>	<b>24,526.8</b>	-	-	-	-	-	-

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.